



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БАТШИРЭЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 13 өдөр

Дугаар А/156

Батширээт сум

**Хүлээн авах
ажлын хэсэг байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.4, 46.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын ойролцоо хөрсний доройтол эвдрэлд орсон газрын судалгаа хийх ажлын гүйцэтгэлд хяналт тавих ажлын хэсгийг доорх бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Б.Төрмөнх - Засаг даргын орлогч


Гишүүд:

Д.Батчимэг- Газрын даамал

Б.Тулга-Байгаль хамгаалагч

2. Ажлын гүйцэтгэлд гэрээний дагуу хяналт тавьж, хүлээн авч танилцуулан ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Б.Төрмөнх)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АЛТАНГЭРЭЛ

232501305